

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ЭРИК СПРОТТЫН ОРОЛЦСОН 7 САЯ ДОЛЛАРЫН ХААЛТТАЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХААЛАА

Хэвлэлийн мэдээ
Нова Скошиа муж, Халифакс хот
2022.12.22

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“**Эрдэнэ Ресурс**” эсвэл “**Компани**”) нь Эрик Спроттын оролцсон хаалттай санхүүжилтийг хаасныг танилцуулахад таатай байна. Энэхүү санхүүжилтийн хүрээнд Эрик Спротт нь 3.4 сая кан.долларын хөрөнгө оруулалт хийн, нийт \$7,000,248 кан.долларыг татан төвлөрүүлээ.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид Эрик Спроттын оролцсон санхүүжилтийг хааж, шинэчлэлтийн жил болох 2023 оныг угтаж буйг дуулгахад таатай байна. Энэхүү санхүүжилт нь Баян Хөндий алтны төслийн бэлтгэл ажлыг эцэслэх, Хөндий Алтны Дүүргийн нөөцийг үргэлжлүүлэн тэлэх боломжийг олгоно.”

Хаалттай санхүүжилтийн хүрээнд Эрдэнэ Ресурс тус бүрийг \$0.27 кан.доллараар үнэлсэн 25,926,844 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг Энгийн хувьцаа болон Энгийн хувьцаа худалдан авах эрх болох хагас ($\frac{1}{2}$) Варрант (“Варрант”)-аас бүрдсэн. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн хугацаанд нэг Энгийн хувьцааг \$0.40 кан.доллараар худалдан авах эрхийг олгоно. Эрдэнэ Ресурс нь санхүүжилттэй холбоотойгоор \$127,699 кан.доллар болон 97,031 ширхэг зуучлалын варрантыг нэмж гаргасан. Зуучлалын варрантыг үнэт цаасны нэгж дэх варранттай адил нөхцөлөөр хэрэгжүүлэх боломжтой.

Санхүүжилтийг компанийн хайгуулын хөтөлбөрүүд, Баян Хөндий алтны төслийн хөгжүүлэлтийн бэлтгэл ажлууд болон эргэлтийн хөрөнгөд зарцуулна.

Эрик Спротт нь 2176423 Ontario Ltd компаниар дамжуулан \$3,383,357.85 үнэлгээ бүхий 12,530,955 ширхэг үнэт цаасны нэгжийг худалдан авсан. Энэхүү худалдан авалтын үр дүнд Эрик Спротт нь нийт 61,225,488 ширхэг хувьцаа, 9,598,827 варрантыг эзэмшиж байгаа нь хорогдуулаагүй хэлбэрээр нийт гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны 17.8%, варрантыг хэрэгжүүлбэл нийт гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны 20.0% эзэмших боломжтой. Энэхүү санхүүжилтэд оролцохоос өмнө ноён Спротт нь 48,694,533 ширхэг хувьцаа болон 3,333,350 варрантыг эзэмшиж байсан нь хорогдуулаагүй хэлбэрээр нийт гаргасан болон эргэлтэд байгаа хувьцааны 15.3%, варрант хэрэгжүүлснээр нийт гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны 16.2% эзэмшиж байсан.

Хувьцааг Эрик Спротт нь хөрөнгө оруулалтын зорилгоор худалдаж авсан. Тэрээр урт хугацааны хөрөнгө оруулалт хийх хэтийн төлөвтэй байгаа бөгөөд зах зээлийн нөхцөл байдал, төлөвлөгөөний өөрчлөлт ба/эсвэл бусад хүчин зүйлийг харгалзан нээлттэй зах зээл эсвэл хаалттай хүрээнд үнэт цаас худалдаж авах эсвэл худалдах боломжтой.

Сэрэмжлүүлгийн тайлантай Компанийн SEDAR дахь хуудаснаас танилцах, эсвэл (416) 945-3294 утсаар холбогдон мэдээлэл авах боломжтой (M5J 2J1 Онтарио мужийн Торонто хотын 200 Бэй Стрийт, Роял Банк Плаза, 2600 тоот).

Торонто хөрөнгийн биржийн (TSX) компанийн тухай журмын 604(a)-д Компанийн хяналтад материаллаг нөлөө үзүүлэх хэмжээний үнэт цаас гаргах эсвэл гаргах боломжтой гүйлгээнд хувьцаа эзэмшигчийн зөвшөөрлийг авах ёстойг заасан. Эрдэнэ Ресурс нь 2020 оны 7, 8 дугаар сард компанийн энгийн хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс Торонтогийн хөрөнгийн биржийн шаардлагын дагуу бичгээр зөвшөөрөл авснаар Компанийн саналын эрхтэй үнэт цаасны 20-оос дээш хувийг эзэмших боломжийг Эрик Спротт болон түүний хяналтад байдаг аж ахуйн нэгжид олгосон.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий хайгуулын 1, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд гуравдагч талын зөвшөөрлийг авах, эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүн, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь

ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН
ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН
МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>